

ЗАВХАН СУДЛАЛ
ТӨВ

МОНГОЛ УЛСЫН ЦАГААТГАХ
АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН
БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИСС

XX

“ЗАВХАН АЙМГААС УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭЖ, ЦАГААТГАГДСАН ХҮМҮҮС”

(Эмхэтгэсэн Н.Мэндбаяр)

Цувралын редактор: **Б.Түвшин**
Ботийн редактор: **Д.Баярсайхан**
Д.Ууганбаатар

Улаанбаатар хот 2021

Энэхүү бүтээлд XX зуунд Монгол Улсад явагдсан их хэлмэгдүүлэлтэнд өртөж хэлмэгдэн, улмаар цагаатгагдсан хүмүүсийн товч мэдээлэл багтсан буй. Завхан аймгийн 24 сумаас нийт 2600 гаруй хүний мэдээлэл энд багтсан байна. Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын хэлмэгдэгсдийн мэдээллийн нэгдсэн санд хадгалагдаж буй энэхүү бариимтанд орсон хүмүүсийн нэр бол ямар нэгэн байдлаар хилс хэрэгт холбогдож улмаар гэм буруугүй нь нотлогдсон тул цагаатгагдсан хүмүүс хэмээн ойлгож болно.

“ЗАВХАН АЙМГААС УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭЖ, ЦАГААТГАГДСАН ХҮМҮҮС”

Эмхэтгэсэн: Нямжавын **МЭНДБАЯР**
/Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын ажлын албаны ахлах референт/

Цувралын редактор: Банзрагчийн **ТҮВШИН**
/“Завхан судлал төв” ТББ-ын тэргүүн/

Ботийн редактор: Даваасамбуугийн **БАЯРСАЙХАН**
/Түүхийн ухааны доктор (Ph.D), профессор/
Доржготовын **УУГАНБААТАР**
/Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын нарийн бичгийн дарга/

Хариуцлагатай редактор: Ганболдын **БЯМБАРАГЧАА**
/Нийгэм соёлын хүн судлалын ухааны магистр/

Хавтасны зураг: ҮТА-ын КГЗДАБА-ын сан хөмрөгөөс ТХС-1-7.

ННА 63.3(5Мон)
ДАА 951.7
З-128

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Г.Лхамжав
Хавтасны дизайнер: Э.Даваажав
Цаасны хэмжээ: 70x100/16
Хэвлэлийн хуудас: ..... хх

ISBN: 978-9919-9691-1-0

“Соёмбо Принтинг” ХХК-д
хэвлэв.

© Зохиогчийн зөвшөөрөлгүй хэвлэн олшруулахыг хориглоно.

ӨМНӨХ ҮГ



“Завхан судлал” цувралын XX боть уншигч танаа түүчээлэн хүрч байна. Бид өмнөх XIX ботид XX зууны эхэн хагаст Завхан аймгийн олон сумдын нутагт байсан сүм хийдүүдэд шавилан сууж асан лам нарын мэдээллийг Тагнуулын Ерөнхий газрын Тусгай архивын баримтаар хүргэсэн билээ. Харин цувралын энэ удаагийн ботид Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын хэлмэгдэгсдийн мэдээллийн нэгдсэн санд хадгалагдаж буй Завхан аймгаас улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэж, цагаатгагдсан хүмүүсийн баримт хүрч байна. Монгол Улсын хэмжээнд улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэж, цагаатгагдсан нийт 31,357 хүн байдаг бол Завхан аймгаас нийтдээ 2,633 хүн байдаг ажээ. Эдгээр хүмүүс бол хийгээгүй хэргийнхээ төлөө гэм буруутан болж цаазаар авахуулж, амьд үлдсэн нь нийгэмдээ гадуурхагдаж байсан эмгэнэлт хувь тавиланг үүрсэн хүмүүс юм.

Тухайн үеийн нийгмийн улс төрийн тогтолцооны золиос нь болсон тэдгээр хүмүүс, үр хойчоос нь Монгол Улсын төр уучлал гуйн жил бүрийн IX сарын 10-ны өдрийг “Хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр” болгон тэмдэглэн өнгөрүүлж буй.

Бидний хэвлүүлж буй “Завхан аймгаас улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэж, цагаатгагдсан хүмүүс” хэмээх энэхүү баримтыг Баянхайрхан сумын уугуул, Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын ажлын албаны ахлах референт Нямжавын Мэндбаяр цуглуулан эмхэтгэж, Улаанбаатарын их сургуулийн ТЗХУ-ны тэнхимийн эрхлэгч, түүхийн ухааны доктор, профессор Д.Баярсайхан болон Шилүүстэй сумын уугуул, Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын нарийн бичгийн дарга Д.Ууганбаатар нар нягтлан зөвлөжээ.

Энэхүү баримтын эмхэтгэлд нийт 2633 хүний хэрхэн хэлмэгдсэн, түүний учир шалтгаан, цагаатгасан байдал зэргийг товч байдлаар багтаасан байна. Тэдгээр хүмүүсийн нэлээдийг нь лам нар эзэлж байна. Мөн Чингис хааны алтан ураг шууд угсааны томоохон тайж, нам төрийн зүтгэлтэн, төрийн болон цэргийн албан хаагч, жирийн малчин гээд нийгмийн бүхий л төлөөлөл багтжээ. Зарим нэгэн баримтыг нь эш татвал, Цогтой засаг З.Дамдин-Авшаа, Дилов хутагт Б.Жамсранжав, нам төрийн нэрт зүтгэлтэн С.Жалан-Аажав зэрэг олон хүний баримт багтсан байна.

Улс эх орон, нам төрийн эсрэг гэм буруутай үйлдэл хийсэн хэмээн буруутгагдсан эдгээр хүмүүс их төлөв дараах үндэслэлээр буруутгагдсан байна.

- Ёнзон хамбын хэрэг. Дийлэнх хүмүүс энэ хэргээр буруутгагджээ. Их төлөв лам хүмүүсийг энэ хэрэгт буруутгажээ.

- П.Гэндэн, Г.Дэмидийн хэрэг. Нам төрийн удирдагч байсан П.Гэндэнтэй холбогдуулан төрийн зарим албан хаагчдыг, Г.Дэмидтэй холбогдуулан цэргийн албан хаагчдыг хэлмэгдүүлжээ.

- “Түгж жанжны хэрэг”. Хөвсгөл, Завхан аймагт гарсан эсэргүүний бослогын удирдагч Б.Түгжтэй хамаатуулан цөөнгүй хүнийг хэлмэгдүүлжээ.

- Л.Цэнд, Ц.Лоохууз, Б.Сурмаажав нарын “Намын эсрэг бүлэг”-ийн хэрэг. 1940-өөд оноос хойш хэлмэгдсэн цөөн тооны хүмүүсийг энэ хэрэгт холбогдуулжээ.

“Завхан аймгаас улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэж, цагаатгагдсан хүмүүс” хэмээх энэхүү бүтээл эрхэм уншигч таны судалгааны ажилд дэм болж, нөгөөтэйгүүр мэдлэг мэдээллийг олж авч чадсан ахул эмхэтгэгч, хэвлүүлэгч бидний чин хүсэл биелэх болно.

Үзэх мэргэд хянан толилмуй.

Банзрагчийн **ТҮВШИН**
/“Завхан судлал төв”-ийн тэргүүн/

УДИРТГАЛ

XX зууны Монголын түүхэн дэх хар бараанаар бичигдэн үлдсэн он жилүүд бол хэлмэгдүүлэлтийн жилүүд билээ. Нийгмийн тогтолцоо, улс төрийн золиос болж, хийгээгүй хэргийнхээ төлөө хилс хэрэгт хэлмэгдсэн тэртээх он жилүүдэд Монголын ард түмэн айдас дунд амьдарч байсныг түүх мартах ёсгүй.

Хэлмэгдүүлэлт шинэ зүйл огтхон ч биш. Мөн зөвхөн Монголын түүхэнд тохиосон зүйл ч биш юм. Улс төрийн тэмцлийн явцад ялж дийлсэн бүлэглэл нь нөгөө хэсгээ егүүтгэх нь ёс мэт дагаж иржээ. Үүнийг “Улс төрийн хэлмэгдүүлэлт” хэмээн тодорхойлж буй. Нэр томьёоны хувьд “Repressio” хэмээх латин үгнээс гаралтай. Төрөөс хууль бусаар хийж буй залхаан цээрлүүлэх бусармаг үйл ажиллагаа хэмээн тодорхойлдог.

1. Хэлмэгдүүлэлт. Түүх ба баримт

Монголын түүхийн тодорхой үеүдэд хэлмэгдүүлэлт тодорхой хэмжээгээр байсаар ирэв. Зарим нэгэн жишээ дурдвал, 1251 онд Мөнх хаан хаан ширээнд суусныхаа дараа төрд тэрсэлсэн хэргээр Өгөдэй болон Цагаадайн угсааныхан, тэрчлэн өмнөх хаадад зүтгэж асан түшмэдийг хэлмэгдүүлэн хороож байв. 1452 онд Эсэн тайш төрийн эрхийг гартаа авахын тулд Зүүн Монголын 33 өрлөгтөн, 44 отогтон, 61 хиуртан тэргүүтэй алтан ургийн ноёдыг хядсан гэх мэтээр олон жишээ дурьдаж болно.

Харин 1921 оны хувьсгалын дараа үзэл бодлын зөрөө, улс төр, албан тушаалын хэнээрхэл, хөрш болон зэргэлдээх улс гүрнүүдийн яс хаях бодлогын уршгаар монголын удирдагчид бие биенээ хардан сэрдэж егүүтгэн хэлмэгдүүлж эхэлжээ. 1922 онд Ерөнхий сайд Д.Бодоог элдвээр гоочлон ажлаас нь халж, улмаар хувьсгалын эсэргүү хүчинтэй сүлбэлдсэн хэмээх хилс хэргээр цаазаар авчээ[1]. 1924 онд Монгол Ардын Намын анхны дарга асан Бүх цэргийн жанжин С.Данзанг намын жанжин шугамыг гажуудуулахыг санаархсан, хувьсгалын эсэргүү үйл ажиллагаа өдөөсөн гэх хилс хэргээр Монгол Ардын Намын III их хурал хуралдаж байх явцад баривчлан шүүлгүйгээр амь насыг нь хороов[2].

Улмаар улс төрийн хэлмэгдүүлэлтийн хамгийн том анхны илрэл нь 1933 онд “Лхүмбийн хэрэг” гэгч зохиомол хэргийг үүсгэн бүрдүүлсэн явдал юм. Лхүмбийн хэрэг гэгчид 2140 хүнийг холбогдуулж, МАХН-ын Төв хорооны нарийн бичгийн дарга Ж.Лхүмбэ зэрэг олон хүнийг дайчлан баривчилж, тэдэнд Японы тагнуулын байгууллагын даалгавраар зэвсэгт бослогод бэлтгэж байсан хэмээн ял тулгаж, 317 хүнийг хилсээр шийтгэжээ. Энэхүү зохиомол хэрэг нь

[1] “Монгол улсын түүх” УБ., 2003. Тал 146.

[2] Лонжид.З, Батсайхан.О “Жанжин Данзан“ УБ., 1995. Тал 31.

Монголд дагаар орсон буриадуудыг цагаантны оргодол, японы тагнуул, Пан-Монголизмын үзэлтэн хэмээн Зөвлөлтийн тал үзэж, монголын зарим удирдагчид түүнийг идэвхтэй дэмжин өөгшүүлснээс үүдэн бий болсон юм.

Дотоодыг хамгаалах газрын ажилд гарсан алдаа завхрал нь төрийн яам болж зиндаа дээшилснээр засрах байтугай улам гүнзгийрчээ. Угаасаа эл газрыг төрийн яам болгон өргөжүүлсэн нь И.В.Сталин, түүний гар хөл бологчид монголын дотоод хэрэгт оролцох "Хар савраа" уртасгасан явдал байв.

Учир нь 1934, 1935 онд монголын нам, төрийн удирдагчид ЗХУ-д ажлын айлчлал хийж, И.В.Сталин, В.Молотов, К.Е.Ворошилов нартай хэд хэдэн удаа уулзаж ирснээс хойш дотоодыг хамгаалах газрынхны дур зоргоороо аашлах явдал эрс нэмэгджээ.

И.В.Сталин "Шинэ нийгмийн байгуулалт гүнзгийрэх тусам ангийн тэмцэл хурцадна" хэмээн номлож, дотоодын хувьсгалын эсэргүү ноёд, лам нартай эрс тэмцэхийг улс төрийн гол чиг шугам болгохыг шаарджээ. Тэд Монголын удирдагчдын нэг Х.Чойбалсанг онцгойлон сонгож, бүх талаар дэмжин хөхүүлэх бодлого баримталсан байна. Зөвлөлтийн шууд оролцоо дэмжлэгтэйгээр тэрбээр шинэ тутам тэргүүлсэн яамныхаа орон тоог өргөжүүлэх, эрх мэдлийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч, Зөвлөлтийн зөвлөх сургагч нарын тоог олшруулжээ[3].

Тэр үед "Хэрэгтэн өөрөө хэргээ хүлээхээс илүү нотолгоо байхгүй" гэсэн А.Я.Вышинскийн онол мөрдөн байцаалтад хүчтэй нэвтэрч эхэлжээ. ЗХУ-д гэм зэмгүй хүмүүсийг хэлмэгдүүлэх явдал өргөн хүрээтэй өрнөж байсан энэ үеэс ЗХУ-ын дотоод хэргийн ардын комиссиарат, БНМАУ-ын Дотоод явдлын яамны удирдлагатай үйл ажиллагаагаа зохицуулж эхэлсэн байна. Ийнхүү 1930-1940-өөд онд явагдсан нийтээр хоморголон улс төрийн талаар хэлмэгдүүлэх ажлын бэлтгэл 1937 оны хагас гэхэд үндсэндээ хангагдсан байна. П.Гэндэнг Крымээс Сочид шилжин очсон өдөр 1937 оны VII сарын 17-нд баривчилжээ. Түүнчлэн тагнуулч бүдүүн хэмээх Ц.Өлзийг ЗХУ-д баривчилжээ. П.Гэндэн, Ц.Өлзий нарыг эрүүдэн байцаасаар "Лхүмбийн эсэргүү хэргийг Дэмид нарын хамт үргэлжлүүлсэн" хэмээх зохиомол мэдүүлгийг ЗХУ-ын дотоод хэргийн ардын комиссариат гаргуулж авчээ.

Маршал Г.Дэмидийг ЗХУ-ын төмөр замын "Тайга" өртөөн дээр хорлон, алснаас хойш хоёр хоногийн дараа буюу 1937 оны VIII сарын 24-нд ЗХУ-ын ДХАК-ын орлогч сайд М.П.Фриновский, Батлан хамгаалах яамны орлогч сайд П.Смирнов, ЗХУ-аас БНМАУ-д суух Элчин төлөөлөгч С.М.Миронов нар Улаанбаатарт хүрэлцэн ирж, "Японоос БНМАУ-ыг эзлэх төлөвлөгөө" гэдгийг Монголын удирдлагад танилцуулжээ. М.Фриновский VIII сарын 28-наар өдөрлөсөн "Хуйвалдаан" буюу "Заговор" хэмээх хэрэгт холбогдуулах 115 хүний нэрсийн жагсаалтыг Чойбалсанд гардуулсан байна. Хоёр хоногийн дараа Гэндэнгийн хэргээ хүлээсэн мэдүүлэг гэгчийг бас өгчээ.

1937 оны IX сарын 2-нд Х.Чойбалсан Цэргийн яамны сайд, бүх цэргийн жанжнаар томилогдов. Ийнхүү Х.Чойбалсан Ерөнхий сайдын нэгдүгээр орлогч сайд, Цэргийн яамны сайд, бүх цэргийн жанжин, Дотоод явдлын яамны сайдын

[3] Болдбаатар.Ж "Улстөрийн хэлмэгдүүлэлт, түүний хор уршиг, үр дагавар" УБ., 2020.

тушаалыг хавсран гүйцэтгэх болж, Засгийн эрх үнэн хэрэгтээ түүний гарт төвлөрчээ. Х.Чойбалсан ЗХУ-ын Сталинч удирдлагын дэмжлэгийг хүлээж байсан учир монголын бусад удирдагчдаас илүү эрх мэдэлтэй, илүү хүчтэй байжээ. 1937 оны IX сарын 10-ны өдөр Монголын түүхэнд аймшигт хар толбо үлдээсэн юм. Тэр өдөр Х.Чойбалсангийн тушаалаар нам, төр, цэргийн удирдах ажилтан 65 хүнийг баривчилжээ. Эл гунигт хар өдрөөс эхлэн төрийн сайдаас эгэл малчныг хүртэл улс төрийн хэлмэгдүүлэлтийн аймшигт сүүдэр дайрч, монголын нийгэм айдас хүйдэст автжээ.

1938 оны IV сард болсон ДЯЯ-ны гүйцэтгэх ажилтны зөвлөлгөөний дараа Х.Чойбалсан тушаал гаргаж, хасгийг “Молда”, буриадыг “Цагаантны оргодол”, чинээлэг аж ахуйтныг “Нударган”, ил тод ярьж шүүмжлэлтэй хандсан хүмүүсийг “Урвагчид”, “Японы талыг баримтлагчид”, бүх зиндааны лам нарыг “Ардын дайсан” хэмээн баривчлахыг анги, хэлтсүүддээ даалгаж хэрэгжүүлжээ.

“Онцгой бүрэн эрхт комисс” гэгч шүүх эрх мэдлийг булаан өөртөө төвлөрүүлж, дотоод яамнаас оруулсан нэрсийн жагсаалтаар асуудлыг шийдвэрлэн, нэг өдрийн хурлаар 129-1278 хүний хэргийг шийтгэж байв. Хэргийг таслан шийдвэрлэхдээ яллагдагчийг хуралд биеэр оруулдаггүй, улсын яллагч, өмгөөлөгчийг оролцуулдаггүй байсан байна.

Баривчлагдагсдын дотор эмэгтэй, тэр тусмаа жирэмсэн эмэгтэйчүүд хэд хэд байжээ. Лхүмбийн хэрэгт хоёр эмэгтэй, П.Гэндэн, Г.Дэмидийн хэрэгт түүний эхнэр Навчаагаас гадна хэд хэдэн жирэмсэн эмэгтэйг буудан алжээ. Ямар ч гэм зэмгүй, давхар биетэй бүсгүй хүнийг буудан хороосон жигшүүрт явдал Монголоос өөр дэлхийн бусад улс орнуудад тэр бүр гараагүй болов уу[4].

Японы тагнуулын байгууллагын даалгавраар БНМАУ-ын нутагт тагнуул үйлдэх, бослого гаргах, алан хядах, хорлон сүйтгэх үйл ажиллагаа явуулсан гэх хилс ялыг 1937-1939 онд баривчлагдсан хүмүүст тулгаж байв. Ийм замаар “Гэндэн, Дэмидийн хувьсгалын эсэргүү байгууллага”, “Ёнзон хамба, дэд хамба нарын эсэргүү байгууллага” гэгч болон түүнтэй холбоотой “улаан Пүрэвийн хэрэг”, “14-ийн хэрэг”, “Дамба, Найдан нарын хэрэг”, “Амар, Довчингийн хэрэг” зэрэг зохиомол хэргүүдийг бий болгожээ.

Улс төрийн хэлмэгдүүлэлтийн хурц үзүүр нь феодализмтай тэмцэх тугийн дор Чингисийн удам, ноёд язгууртны угсааг үндсээр нь таслахад чиглэж байв. 1938 оны VIII сард Х.Чойбалсангаас нууц алба, дотоодын тагнуулын ажлыг хүчтэй болгох зорилго бүхий маш нууц тушаалд тодорхойлсноор хар ноёд, тайж зэрэг 900 хүнийг дайсагнагч этгээд гэж үзэж байсан бол ажил хэрэг дээрээ 1940 он гэхэд 1489 тайж нарыг баривчилж, бараг толгой дараалан буудсан байна. Мөн Монголд шинээр дөнгөж бүрэлдэж байсан сэхээтний давхрааг хоморголон устгажээ.

Улс төрийн хэлмэгдүүлэлтийн жилүүдэд Дотоод яам, түүний харьяа байгууллагууд эрх баригч нам, төрийн байгууллагуудын дээр гарч, бүхнийг айлган сүрдүүлэх, дарамтлах газар болон хувирчээ. МАХН-ын IX Их хурлаас (1934 он) сонгогдсон намын төв хорооны 51 гишүүний 83,6 хувь нь улс төрийн

[4] Болдбаатар.Ж “Улстөрийн хэлмэгдүүлэлт, түүний хор уршиг, үр дагавар” УБ., 2020.

хилс хэргээр хэлмэгджээ. Намын анхдугаар их хурлаас (1921 он) IX их хурал (1934 он) хүртэл намын Их болон Төв хорооны бүгд хурлаас сонгогдсон намын төв хорооны дарга, орлогч, нарийн бичгийн даргаар сонгогдсон хүмүүс (Өвчнөөр нас эцэслэсэн Б.Элдэв-очир, 1939 оны VII сард нарийн бичгийн даргаар сонгогдсон Д.Дамбыг эс оруулбал) толгой дараалан баривчлагдаж, бүгд цаазын тавцанд очжээ.

Намын IX их хурлаас сонгогдсон НТХ-ны тэргүүлэгч 11 гишүүнээс зөвхөн Х.Чойбалсан ганцаар үлдсэн байна. Дээр дурдсан бүхэн нь өгүүлэн буй үед улс төрийн хэлмэгдүүлэлтийн субьект байх байтугай МАХН зохион байгуулалтын хувьд намын дүрэмд заасны дагуу оршин тогтнож чадахаа больсныг харуулж байна. Төрийн эрх барих, хууль тогтоох дээд байгууллагын үйл ажиллагаа хэлмэгдүүлэлтийн харгайгаар бараг тасалджээ. тухайлбал, БНМАУ-ын VII их хурлаас сонгогдсон бага хурлын гишүүдийн бараг тал хувь нь баривчлагджээ. Чингэснээр хууль тогтоох дээд байгууллага Үндсэн хуулийн дагуу ажиллах чадваргүй болсон байна. Улсын бага хурлын гишүүнийг зөвхөн бага хурлын тэргүүлэгчдийн буюу онцгой тохиолдолд бага хурлын даргын зөвшөөрлөөр баривчилж мөрдөн байцаах тухай 1933 онд батлагдсан “Монгол Ардын Улсын Бага хурлын гишүүдийн тухай” дүрмийн заалтыг огтхон ч хэрэгсэхгүй байв. Үндсэн хуульд заасны дагуу жилд 2 удаа хуралдах ёстой Улсын бага хурал 1937, 1938 онд хуралдаагүй байна.

Төрийн хүчирхийллийн гол хэрэгсэл-ардын арми, цагдаа, тэр ч байтугай дотоодыг хамгаалах байгууллагын өөрийнх нь олон зуун ажилтнууд ч улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртжээ.

1937 оны IX сараас XI сар хүртэлх хугацаанд Цэргийн яам болон жанжин штаб, корпус, дивизүүдийн удирдлагыг бараг бүхэлд нь дайчлан баривчилжээ.

И.В.Сталин, түүний Монгол дахь гар хөл бологчдын залхаан цээрлүүлэлт нийгмийн оюунлаг давхраа-лам нарын эсрэг чиглэгджээ. И.В.Сталин 1934, 1936 онуудад П.Гэндэн, А.Амар зэрэг Монголын удирдагчдыг ЗХУ-д айлчлахад эхлээд лам нарт туслах, сэнхрүүлэх маягаар тойрон бүслэх аргаар асуудлыг шийдвэрлэх зөвлөгөө өгч байснаа сүүлдээ лам нарыг даруй шууд даран устгахыг тулган шаардах болсон юм.

Баривчлагдсан хүмүүст ямар нэг аргаар хилс хэрэг тулган хүлээлгэж, зохиомол мэдүүлэг гаргуулж авах нь Дотоодыг хамгаалахын ажилтнуудын гол үүрэг, зорилт байлаа. Байцаагчид баривчлагдагсдыг өндөр сандалд хөлийг нь унжуулан суулгаж, олон хоног нойр хоолгүй тамлан, жижүүрлэн байцааж, хилс хэрэг хүлээлгэж байв. Байцаалтыг гол төлөв өглөөний 10 цагт эхэлж оройн 16 цагт завсарлаад, оройн 19 цагт дахин үргэлжлүүлэн, өглөөний 6 цаг хүртэл байцааж байжээ. Зарим тохиолдолд өглөөний 9 цагаас оройн 17 цаг хүртэл, оройн 17 цагаас шөнийн 1 цаг хүртэл, шөнийн 1 цагаас өглөөний 9 цаг хүртэл жижүүрлэн байцааж байсан аж.

Мөрдөн байцаалтын асуултыг эхэн үедээ байцаагч бүр өөр өөрийнхөөрөө тавьдаг байснаа сүүлдээ нэгдсэн журамд шилжжээ. Асуултад үл хариулж,

хэргээ хүлээхгүй бол дараах бусармаг аргуудыг ээлжлэн хэрэглэж, эрүүдэж байжээ. Үүнд:

1. Хэрэгт холбогдогсдыг хэл амаар доромжилж, “Хуйхыг чинь ярж, хулхинд чинь сум зооно”, “Эрэг дэрлүүлж, элсэн хөнжил нөмөргөнө”, “Чи одоо хамуутай золбин нохойноос үнэгүй болсон, чамайг нам буудна” гэх мэтээр заналхийлж, буу тулгаж айлган сүрдүүлж байв.

2. Баривчлагдагсдын нүүр рүү нулимах, эмзэг газар нь няслах, чих, хамрыг нь мушгих, үзэг харандаагаар хатгах, шугамдах, тамхины гал, монгол гаансны халсан толгойгоор төөнөх, жигнэх, цохиж тогших зэргээр авирлаж байжээ.

3. Хацар нүүр, чихний тус газраар алгадах, элэг, төмсөг гэх мэт эмзэг эрхтэн рүү нь өшиглөх, бичгийн чулуун хэрэгсэл, сандлын хөлөөр нүүр нүдгүй балбах, шүдийг нь цөм цохих, үсдэж шалан дээгүүр чирч гулдрах, даавуунд элс чулуу боож нүдэх, кабелийн гурав, дөрөв давхарласан утсаар ороолгох зэргээр харгислаж байв.

4. Хүйтэнд гадаа нүцгэн зогсоох, цонх задгайлж дааруулах, хүйтэн мөстөж цантсан өрөөнд дотуур хувцастай нь өчиг өгтөл нь хорих, гар, хөлд нь гав гинж хийх, бууны бөгсөөр ууц руу, тархи толгой руу ёврох нь олонтаа байжээ.

5. Хэргээ хүлээвэл амь өршөөж, хөнгөн ял эдлүүлнэ гэж ятгаж хууран зохиомол хэрэг хүлээлгэх зэрэг олон янзын арга ов мэх хэрэглэж байжээ. Чингэхлээр тэр цагт Монголд ЗХУ-д мөрдөн байцаалтад ашиглаж байсан залхаалтын харгис аргуудыг үндсэнд нь авч хэрэглэж байсан гэж үзэж болно. Харин манай оронд харх байгаагүй учраас баривчлагсдыг зодож нүдэж, цус нөжтэй нь хольж, ухаан алдуулаад хархтай зооринд хаяж, амьдаар нь хүний цусыг сорж зулгаалгадаг харгис арга л арай нэвтрээгүй бололтой[5].

Хөдөө орон нутагт баригдагсдыг буудан хороох явдал заримдаа хоттой хонь, малаасаа өвлийн идэш хийхээс илүү амархан шийдэж байсан аж. Дотоод яамны Дорноговь дахь хэлтэс 1938 онд 300 гаруй хүн бариад аймгийн шоронд багтахгүй болохоор нь 30 шахам хүнийг буудан алж зай гаргаж байжээ.

Улс төрийн их хоморгод өртсөн хүмүүсийн дотор цөөнгүй эмэгтэйчүүд байсан юм. Тухайлбал, Монгол улсын хэмжээт эрхт эзэн хааны бэлбэсэн хатан Н.Гэнэнпэл (1905-1938), Цэргийн яамны сайд, Бүх цэргийн жанжин Г.Дэмидийн гэргий Богдановын Навчаа (1906-1937), түүний эгч Б.Зина, ДХГ-ын дарга Д.Намсрайн гэргий М.Дулмаа (1907-1937), хошууны дарга Д.Дунгаржид (1901-1933), багш З.Долгор (1906-1939) зэрэг эмэгтэйчүүд байсны дотор Д.Дунгаржид, Б.Навчаа нар жирэмсэн байсныг өчүүхэн ч хайхраагүй нь хүнлэг ёсноос ангид, үзэшгүй жигшүүрт явдал болсон байна. Мөн Г.Дэмидийн төрсөн эцэг, ах, дүү нарыг, З.Шижээгийн төрсөн эцэг, хоёр ахыг хороож байсны сацуу хорин нас хүрээгүй хэд хэдэн залуучуудыг хувилгаан дүрд тодорсон эсэргүү хэмээн баривчилж, ял ногдуулж байсан ба 70-аас дээш настай, хүнд өвчинд нэрвэгдсэн олон хүнийг сэжигтнээр татаж, амь насыг нь хохироож байв[6].

[5] Болдбаатар.Ж “Улстөрийн хэлмэгдүүлэлт, түүний хор уршиг, үр дагавар” УБ., 2020.
[6] “Монгол улсын түүх” УБ., 2003. Тал 146.

Завхан аймгаас хилс хэрэгт холбогдон хэлмэгдсэн хүмүүст тулгаж байсан ялыг нь судлан үзвэл дараах хэд хэдэн хэргийг тулган хүлээлгэж байжээ.

Ёнзон хамбын хэрэг. Хамгийн олон хүнд хүлээлгэсэн хэрэг нь Ёнзон хамбын хэрэг байна. Энэхүү Ёнзон хамба хэмээгч бол Цэдэнгийн Лувсанхаймчиг хэмээх түвэд хүн юм. Түвэдийн Дашлхүмбэ хийдэд шавилан сууж байгаад Жавзандамба хутагтын багшаар сонгогдон Монгол нутагт амьдарч байсан хүн юм. Ёнзон хамба Лувсанхаймчиг нь “Хувьсгалын эсэргүү лам нарын Гандангийн төв” хэмээх зохиомол хэрэгт шийтгэгдэн 1937 оны X сарын 7-ны шөнийн 00 цаг 42 минутад Даландавхарт цаазаар авахуулан буудуулжээ.

Түүнд Япон улстай холбоотой, Банчин Богдын даалгавраар Монгол Улсад тагнуулын ажил хийхээр ирж, тус улсын бүхий л байдлыг тагнан мэдэж, гадаадын дайснуудад мэдээлж байсан, ардын дотор худал цуурхал хүчтэй тараан дэлгэрүүлсэн төдийгүй аймаг, хотуудад хувьсгалын эсэргүү салбар бүлгэм үлэмжхэн байгуулж, улсын эд хөрөнгийг галдан шатаах, хорлон сүйтгэх ажил явуулсан, Монгол Улсад Банчин богдыг япон цэргийн хамтаар ирүүлэхийн тулд зэвсэг, орон сууц, хоол хүнс, эд хөрөнгө хуримтлуулан хадгалах, зэвсэг бүхий хүмүүсийг элсүүлэх, улмаар дотоодод зэвсэгт бослого гаргах бэлтгэлийг олон жилийн турш үргэлжлэн хийсэн, эцэст нь Монгол ардын хувьсгалт засаг төрийг устган сөнөөж, харгис хаант засгийг байгуулан ард түмнийг эзэрхэг түрэмгий нарын колони болгон эзлүүлж, гаслант байдалд оруулахыг завдсан өөдлөшгүй дайсан этгээд мөн хэмээн ял тулгасан байдаг.

“Лам нарын хувьсгалын эсэргүү төв” хэмээх байгууллагын толгойлогч гэгч Ёнзон хамба Лувсанхаймчиг болон уг хэрэгт холбогдсон нэр бүхий 22 ламд дээрх ялыг завхралын үед хэрэглэж байсан харгис хэрцгий элдэв арга хэрэглэн тулган хүлээлгэжээ. Улмаар багш шавийнх нь холбоогоор хавтгайруулан бие биедээ элсэгдсэн болгож байсан, баримт нотолгоо болгожээ.

1929 онд зохион байгуулагдсан хэмээх “Лам нарын хувьсгалын эсэргүү төв” нь Архангай, Өвөрхангай, Ховсгөл, Сэлэнгэ, Өмнөговь, Дорноговь, Завхан, Дорнод, Хэнтий зэрэг арван аймгийн 48 том хүрээ, хийдтэй харилцаа холбоотойгоор эсэргүү салбар байгуулж, хорт үйл ажиллагааг идэвхтэй явуулж байсан хэмээн ялын төлөвлөгөөнд дурджээ. Бүртгэлд ороогүй эгэл лам, хар хүнийг алдсан оргосны оронд нөхөх, тоо бөглөх үүднээс баривчлан хэлмэгдүүлэх, мухар сүсгийн харгайгаар сайн дурааараа баривчлагдах нэн харамсалтай явдал гарч байжээ. Тэдгээр 48 хүрээ хийдэд Завхан аймгийн нутагт байсан хүрээ хийдүүд багтаж байсан тул тэрхүү Ёнзон хамбын хэрэгт хам хэрэгтэн болж хэлмэгдсэн байна. Энэ хэргээр их төлөв лам нарыг хэлмэгдүүлжээ.

“Түгж жанжны хэрэг”. 1932 онд гарсан зэвсэгт тэмцлийн нэг удирдагч нь Батболдын Түгж буюу Түгж жанжин байсан юм. Завхан аймгаас хэлмэгдсэн хүмүүсийн нэлээдийг нь энэхүү Түгж жанжинтай хамаатуулан хэлмэгдүүлсэн

байна. Батболдын Түгж нь хуучнаар Засагт хан аймгийн Эрдэнэдүүргэгч засгийн хошуу, одоогийн Хөвсгөл аймгийн Цэцэрлэг суманд 1892 онд төрсөн, Их Хотогойд овогтой, “Ногоон” хочтой, бичиг үсэггүй нэгэн байв. Айлын зарц явсан тэрээр хурц ухаантай сэргэлэн, овсгоотой нэгэн байсан аж. Хувийн малаа маллаж, ан гөрөө хийн аж төрдөг, багын залжин, овсгоо сүйхээтэй, үүгээр түүгээр хэсэмтгий, хэлэмгий доломгой, баяд ноёдод таагүй, архи уучихдаг, холхон явж хазаар гүйлгээд, олсон олзоо олонтой хуваачихдаг сайн эр, тэр хэмжээндээ тодорхой хүрээлэлтэй, түүнийхээ дотор нөлөө бүхий билиг танхайдуу нөхөр байсан гэдэг. Ялангуяа ан авд адтай, онц сайн бууддаг байжээ.

Б.Түгж баруун дөрвөн аймагт гарсан 1932 оны зэвсэгт бослогод анх Самбуу дүвчингийн шар цэрэгт 1932 оны IV сард элсэн орсноор бослогод оролцож эхэлсэн байна. Самбуу дүвчингийн цэрэгт байхдаа Ардын улаан цэрэгтэй хийсэн 10 орчим тулалдаанд эрэлхэг зоригтой тулалдсан тул Жанжин цол авч өргөмжлөгдсөн байна. Түүнээс хойш бослогод идэвхитэй оролцон голлох толгойлогч нарын нэг болсон бөгөөд МАХН-ын гишүүн, идэвхитэн, ардын цэргийн албан хаагч болон Ардын засгийг талархагч гэзд 100 орчим хүнийг өөрийн гараар зүрхийг нь сугалах зэрэг зэрлэг аргаар амь насыг нь хороосон гэдэг. Бослогын гол хүчийг зэвсгийн хүчээр 1932 оны VIII сард дарсанаас хойш бут цохиулсан цэргээсээ үлдсэн цөөн тооны хүний хамт уул хадаар нуугдан байж байгаад баригдсан байна.

1933 оны IV сарын 19-ний өдөр 16 цагт Чимэдийн Самбуу дүвчин, Самбуугийн Буриад, Чойжин, Аюурзана, Түгж нарын зэрэг 39 этгээдийн хэргийг мөрдөн байцааж, хууль цаазны ёсоор таслан шийтгэсэн байна. Уг хурлаас Б.Түгжид цаазлан хороох ял шийтгэж гүйцэтгэжээ.

Бидний хэвлүүлэн буй баримтанд буй нэгэн жишээг эш татан өгүүлье. Ж.Шагдар хэмээх Тэлмэн сумын харьяат хүнд ял тулгахдаа, “... 1932 онд эсэргүү жанжин Түгжийн цэрэгт орж улаан цэрэгтэй идэвхитэй байлдсан хэрэг, 1935 онд эсэргүү Лувсандагвад элссэн, бүлгэмдээ 2 хүн элсүүлсэн, нууц хуралд суусан, дотоодод тагнуул үйлдсэн” хэмээн буруутган баривчилжээ.

П.Гэндэн, Г.Дэмидийн хэрэг. П.Гэндэн бол Монгол Улсын 11 дэх ерөнхий сайд болно. Харин Г.Дэмид бол Ерөнхий сайдын орлогч сайд, Цэргийн Явдлын Яамны сайд, Бүх цэргийн жанжнаар ажиллаж байсан зүтгэлтнүүд болно.

1935 оны эцсээр Монголын Ерөнхий сайд П.Гэндэн ба түүнийг дагалдаж Цэргийн яамны сайд, бүх цэргийн жанжин Г.Дэмид, ДХГ-ын дарга Д.Намсрай нар ЗХУ-д төрийн айлчлал хийж, Зөвлөлтийн удирдагчидтай уулзаж Монголын дотоод, гадаад байдлын талаар биечлэн танилцуулжээ. ЗХУ-ын удирдагчид Монголын дотоод байдлыг нилээд гүнзгий сонирхож олон зүйл асууж лавласан байна. Энэхүү уулзалтаас П.Гэндэн, Г.Дэмид нарын хувь заяа шалтгаалжээ.

1933,1934 онд И.В.Сталинаас монголд удаа дараа тулгасан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй нь Ерөнхий сайд П.Гэндэнтэй холбоотой хэмээн ЗХУ-ын удирдагчид үзэж, түүнийг албан тушаалаас нь зайлуулахаар багагүй анхаарч байлаа. 1936 оны эхээр Зөвлөлтийн удирдагчдын шаардлагаар П.Гэндэнг

огцруулж ЗХУ-д нутаг заан суулгав. ЗХУ-ын Дотоод хэргийн ардын комиссарын газар П.Гэндэн, Ц.Өлзий нарыг байцааж, тэднийг Ж.Лхүмбийн хэрэгт оролцож байсан ба түүнийг баривчлагдсанаас хойш Г.Дэмид, П.Гэндэн нар уул хэргийг үргэлжлүүлж байсан гэдэг мэдүүлэг гаргуулж авсан байна.

Яг энэ үед 1937 оны VIII сарын 23-нд маршал Г.Дэмид ЗХУ-д албан хэргээр одох замдаа хорлогдон нас баржээ. Түүнээс ганцхан хоногийн дараа ЗХУ-ын ДХАК-ын газрын орлогч сайд М.П.Фриновский БХЯ-ны орлогч сайд Смирнов, ЗХУ-аас БНМАУ-д суух бүрэн эрхт элчин төлөөлөгч С.Н.Миронов нар Улаанбаатарт ирж, Японоос БНМАУ-ыг эзлэх төлөвлөгөө гэгчийг Монголын удирдагчдад танилцуулж “Хуйвалдаан” буюу “Заговор” гэгч гэмт хэрэгт холбогдсон 115 хүний нэрсийн жагсаалтыг ДЯЯ-ны сайд Х. Чойбалсанд гардуулсан байна. Энэхүү 115 хүний нэрсийн дотор БНМАУ-ын яам, тусгай газар, цэргийн яамны удирдах ажилтнаас эхлээд төв, орон нутгийн байгууллагын албан хаагчид, соёл, шинжлэх ухаан, эрүүлийг хамгаалах салбарын ажилтнууд байлаа. Мөн эсэргүү П.Гэндэнгийн мөрдөн байцаалтын мэдүүлэг гэгчийг бас авчирсан байлаа.

1937 оны IX сарын 10-ны шөнө ЗХУ-ын ДХАК-ын газраас ирүүлсэн нэрсийн жагсаалтын дагуу цэрэг, төр захиргаа соёлын салбарын ажилтан 69 хүнийг нэг зэрэг баривчилснаар Монгол орныг нийтэд нь хамарсан их залхаан цээрлүүлэлт, нийтээр нь хоморголон хилсдүүлэх ажиллагаа гараагаа эхэлсэн байна.

Завхан аймгийн нам төрийн ажил хийж байсан нэлээд олон тооны хүмүүсийг хэлмэгдүүлэхдээ энэхүү “Гэндэн Дэмидийн хэрэг” хэмээгчийг ашиглажээ.

“Намын эсрэг бүлэг”-ийн хэрэг. 1940-өөд оноос Монголын нийгмийг хэт үзэл сурталжуулан, үндэсний түүх, соёлоо дээдэлсэн бүхнийг үндсэрхэх үзэлтэн, улс орны удирдлага, хөгжлийн дутагдал, доголдлыг шүүмжлэлтэй, олон ургалч үзлийн үүднээс хандсан сэхээтнүүдийг үгүйсгэх үзэлтэн, Монгол, Зөвлөлтийн харилцаанд гарч байсан сөрөг талыг хэлж ярьсан хүнийг Зөвлөлтийн эсрэг үзэлтэн, “Намын эсрэг бүлэг” хэмээн хавчин хяхаж эхэлсэн байна.

МАХН-ын Төв Хорооны III бүгд хурал дээр “Д.Төмөр-Очирын намын эсрэг үйлдсэн ажил явуулгын тухай”, V бүгд хурал дээр “Л.Цэндийн намч биш ажил явуулгын тухай” тогтоол гаргаж, тэднийг хавчин хэлмэгдүүлж байв. МАХН-ын Төв Хорооны VI бүгд хурал дээр “Ц.Лоохууз, Б.Нямбуу, Б.Сурмаажав нараас намын эсрэг бүлэглэсэн явууллага хийсэн тухай” тогтоол гаргаж, намын жанжин шугамыг эсэргүүцсэн, урагшлах замд тохиолдож байгаа бэрхшээл, дутагдлыг дөвийлгөн ашиглаж, намын бодлого буруу мэтээр харуулахыг оролдсон, улс орны ололт, амжилтыг үгүйсгэсэн, ЗХУ, социалист орнуудтай хамтран ажиллахын ач тусыг дутуу үнэлсэн, үндсэрхэх үзлийг шууд хамгаалан, түүний хор аюулыг үгүйсгэж, Д.Төмөр-Очир, Л.Цэнд нарыг далдуур дэмжсэн гэх зэргээр буруутгасан ажээ[7].

Гэтэл тэд бол Намын Төв Хорооны удаа дараагийн Бүгд хурал дээр улс орны хөгжлийн асуудал, нам, засгийн удирдагчдын дутагдал, доголдлыг шүүмжлэн,

[7] https://mongoltoli.mn/history/h/745

социалист хөгжлийн өөр, өвөрмөц замыг сонгохын төлөө санаа тавьж байсан удирдах ажилтнууд болно. Ц.Лоохууз, Б.Нямбуу, Б.Сурмаажав нар болон бусад нэр бүхий хүмүүсийг хөдөө нутаг заан суулгаж, бага цалинтай ажил эрхлүүлэн, явах гишгэх, ярих хэлэхийг нь хүртэл цагдаж, хүний эрхийг ноцтой зөрчиж байв. Тэднийг МАХН-ын түүхэнд “Намын эсрэг бүлэг” хэмээн тэмдэглэж байв. МАХН-ын эрх баригчид “Намын эсрэг бүлэг” гэгч асуудлыг шийдвэрлэснээр Монголын нийгмийн удирдлагын дотоод хямрал шувтарч, 1960-аад онд нэг хүний захиран тушаах систем тогтсон ажээ.

Завхан аймгаас улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэж, цагаатгагдсан зарим хүмүүсийг 1960-аад оны үеийн энэхүү “Намын эсрэг бүлэг” хэмээгчид хамааруулсан нь бий.

2. Цагаатгал

Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисс (ЦАУЗБУК) нь 1990 оны XII сарын 25-ны өдөр БНМАУ-ын Ерөнхийлөгчийн 56 дугаар зарлигаар гуч, дөчөөд он, тавиад оны эхэн үе, мөн 1960 оноос намын хэлмэгдүүлэлтэд өртөж, хилс хэрэгт татагдаж, хэлмэгдсэн иргэдийн асуудлыг үргэлжлүүлэн судлах зорилгоор бие даасан, төрийн түр байгууллага хэлбэрээр байгуулагдсан юм.

Бие даасан байгууллага хэлбэрээр байгуулагдахаас өмнө 1956-1962 онд АИХ-ын Тэргүүлэгчдийн дэргэдэх Цагаатгах ажлыг эрхлэх комисс (ЦАЭК), 1989-1990 онд МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны дэргэдэх Цагаатгалын комисс (ЦК) гэсэн бүтцээр ажиллаж байсан. Дээрх комиссууд нь тухайн цаг үедээ үүргээ гүйцэтгэн татан буугдсан боловч улс төрийн цагаатгалын асуудлыг иж бүрэн, цогцоор нь авч үзэж чадаагүй, дутуу хагас орхисноос шалтгаалан, олон түмний хүсэлт, шаардлага, эрэлт хэрэгцээг үндэслэн, цагаатгалын ажлыг дахин цааш нь үргэлжлүүлэх шаардлага гарсан тул ийнхүү төр, засгийн биеэ даасан комисс байгуулагдсан юм.

Улсын комисс нь язгуур угсаа, гарал үүсэл, үзэл бодол, шашин шүтлэг, хөрөнгө чинээ, нийгмийн байдлын улмаас улс төрийн хэрэгт хилсээр шийтгэгдсэн, нам, захиргааны байгууллагаас арга хэмжээ авагдсан хэлмэгдэгчдийг цагаатгуулах, хэлмэгдэгч болон түүний гэр бүлийн гишүүдэд нөхөх олговор олгох, хэлмэгдэгчдийн дурсгалыг мөнхжүүлэх, тэдний нэр төрийг сэргээн сурталчлахад холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдийг татан оролцуулах ажлыг зохион байгуулах зорилготой Улсын хэмжээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг төрийн байгууллага бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан комиссын дүрэм болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон үйл ажиллагаагаа явуулж ирэв.

Улсын комисс нь төрийн бие даасан орон тооны бус байгууллага бөгөөд үйл

ажиллагааныхаа тайланг Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлд тайлагнадаг, комиссын бүрэлдэхүүнийг Монгол Улсын Ерөнхийлөгч баталдаг, комиссын нарийн бичгийн дарга нь комиссын өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж зохион байгуулдаг бөгөөд түүний ажлын алба нь төрийн орон тооны байгууллага юм.

Улсын комиссын даргаар Монгол Улсын Их Хурлын дэд дарга ажилладаг бөгөөд гишүүд нь Улсын комиссын нарийн бичгийн дарга, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайд, Улсын Ерөнхий прокурор, Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн, Тагнуулын Ерөнхий газрын дарга, Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах газрын дарга, Улсын комиссын ажлын албаны дарга гэсэн есөн албан тушаалтнаас бүрдэнэ. Аймаг, нийслэл, сум, дүүргүүдэд тухайн орон нутгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга, нарийн бичгийн дарга нар Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссын дарга, нарийн бичгийн даргаар тус тус ажилладаг бөгөөд баг, хороонд улс төрийн цагаатгалын ажлыг Засаг дарга нар хариуцдаг. Мөн холбогдох хуулийн байгууллагуудад энэ асуудлыг хариуцсан ажилтан ажилладаг болно.

Түүнчлэн комисс, түүний ажлын албаны хэрэгжилтийг хангаж, үйл ажиллагаандаа удирдлага болгон ажилладаг “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хууль” 1998 оны I сарын 02-ны өдөр батлагдсан бөгөөд уг хуулийн голлох зүйл, заалтууд буюу хэлмэгдэгчийг цагаатгах (Хуулийн 6.3 дахь заалт), нөхөх олговрын нэхэмжлэл гаргах (Хуулийн 12.3 дахь заалт) зэрэг заалтуудын үйлчлэлийн хугацаа 2011 онд дуусч комисс, түүний ажлын албаны өдөр тутмын ажил, үйлчилгээ суларч, цалгардсан байдалтай байсан бөгөөд 2017 оны IV сараас Цагаатгалын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан ажиллаж 2018 оны I сарын 12-ны өдөр УИХ-ын чуулганаар батлуулснаар 2011 оноос хойш зогсонги байдалд орсон Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисс, түүний ажлын албаны үйл ажиллагаа эрчимжиж иргэд үзүүлэх үйлчилгээ жигдэрч эхэлсэн.

Мөн Улсын комиссын дэргэд 1991-2014 он хүртэлх хугацаанд улс төрийн хэлмэгдүүлэлтийг судлан түүний шалтгаан нөхцлийг тогтоож цаашид хүний эрхийг зөрчих, хэлмэгдүүлэлт аль нэг хэлбэрээр давтагдахаас урьдчилан сэргийлэх нийгэм, улс төрийн баталгаа буй болгох чиглэлээр эрдэм шинжилгээний суурь ба хавсарга судалгааны ажлыг эрхлэн явуулж, шинжлэх ухааны зөвлөмж үндэслэл боловсруулах зорилготой Улс төрийн талаар хэлмэгдэгсдийн судалгааны төв ажиллаж байв.

Уг төв нь хэлмэгдсэн төр, нийгэм, цэрэг, шашин олон нийтийн зэрэг байгууллагын зүтгэлтнүүдийн түүх намтрын судалгаа хийх, 30 орчим мянган иргэний хэлмэгдсэн, цагаатгагдсан мэдээллээр “Мэдээллийн нэгдсэн” бааз байгуулах, хээрийн судалгааны ажил хийгдэж хэлмэгдүүлэлттэй холбоотой

түүх, дурсгал, музей, зарим сүм хийдээр орж, их хэлмэгдүүлэлтийн үед сүм хийд, лам нарыг хэрхэн хэлмэгдүүлсэн талаар үе дамжин уламжлагдсан аман ярианы тэмдэглэл хийх, зурагжуулах зэрэг түүх судлалын ажлыг явуулж байсан.

Түүнчлэн судалгааны төв нь улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн хүний амьдрал, үйл ажиллагааны талаар 24 хүний намтар, “Улс төрийн талаар хэлмэгдэгсдийн намтрын товчоон” цуврал бүтээлийн 18 боть ном, Намтрын товчоон 3 боть, “Лам нарыг эгүүтгэсний учир”, “Харьд хэлмэгдсэн монгол иргэд” сэдэвт суурь судалгааны бүтээлүүд, “Монгол дахь хэлмэгдүүлэлтийн эхлэл”, “Эрэгдэндагвын 38-ын хэрэг”, “Аж үйлдвэрийн комбинатын хэрэг” “Лхүмбийн хэрэг”, “Үнэний төлөө” баримтат кино зэрэг бүтээлийг олон нийтийн хүртээл болгохоос гадна хэлмэгдэгчдийн дурсгалын мөнхжүүлэх, хэлмэгдлийн үр дагавар, хор уршгийг хойч үедээ таниулах, Монгол Улсад хэлмэгдлийг дахин гаргуулахгүй байх талаар сургалт, сурталчилгааны чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж ирсэн.

2020 онд Улсын комисс байгуулагдсаны 30 жилийн ой тохиосон бөгөөд ойн хүрээнд Монголын төр, шашны нэрт зүтгэлтэн, сайд Егүзэр хутагт Ж.Галсандашийн мэндэлсний 150 жилийн ой, хэлмэгдсэний 90 дэх жилийн хүрээнд “Егүзэр хутагт: түүхэн зүтгэлтэн ба улс төрийн хэлмэгдүүлэлт” олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, “Хэлмэгдэл ба Цагаатгал: Түүх ба баримт” ном, “Монгол Улсын тусгаар тогтнол ба Ерөнхий сайд Ц.Жигжиджавын нийгэм эдийн засгийн шинэтгэл” эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл, Нийслэлийн салбар комиссоос “Улаанбаатар дахь хэлмэгдэл ба цагаатгал” номыг тус тус хэвлэн гаргаж олон нийтийн хүртээл болгоод байна.

Улсын комиссын ажлын алба үйл ажиллагааны хүрээнд үндсэн 3 чиглэлийг баримтлан ажилладаг. Үүнд

- Хэлмэгдэгчдийг цагаатгуулах. Улсын хэмжээнд 1922-1990 оны хооронд улс төрийн хэрэгт шийтгэгдсэн иргэдээс 2020 оны XII сарын 31-ний өдрийн байдлаар нийт **31357** иргэнийг цагаатгаад байна.

Цагаатгасан байгууллагаар ангилбал:

- Дотоод явдлын яамны дэргэдэх Тусгай комиссын тогтоолоор суллагдсан (1939-1955 он) - **2017**,
- Ардын Их Хурлын дэргэдэх Цагаатгах ажлыг эрхлэх комиссын тогтоолоор (1956-1962 он) - **532**,
- Монгол Улсын Дээд шүүхийн магадлал, тогтоолоор (1939-2020 он) - **26140**,
- Монгол Улсын Ерөнхий Прокурорын газрын тогтоол, шийдвэрээр (1939-2020 он) - **2432**,
- Нам, төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр хэлмэгдэж анхан шатны шүүхээр цагаатгагдсан (1990-2020 он) - **203**,
- ЗСБНХУ-д цагаатгагдсан (1990 оноос өмнө) – **33** иргэн байна.

- Үүнээс 1939-1991 онд цагаатгагдсан – **6775**, 1992-2020 онд цагаатгагдсан – **24582** иргэн байна.

- Хэлмэгдэгчийн нөхөх олговор олгох. Цагаатгалын хууль батлагдсан 1998 оноос хойш хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтад тусгагдсан (1 сая болон 500,0 мянган төгрөг) нөхөх олговрын хүрээнд нийт 16 тэрбум 565,5 сая төгрөгийн нөхөх олговрыг цагаатгагдсан хэлмэгдэгчид, тэдний гэр бүл, үр хүүхэд, ач, зээ, ах, эгч, дүү зэрэг **18,336** иргэнд олгоод байна.

Харин 2018 онд батлагдсан Цагаатгалын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар нэмэгдсэн 13 дугаар зүйлийн 13.2 дахь заалт буюу хэлмэгдүүлэлтийн хор уршгийг өөрийн биеэр мэдэрч, бие махбодь, сэтгэл санааны хохиролд хамгийн ихээр өртсөн хэлмэгдэгч, түүний эхнэр (нөхөр), төрсөн болон үрчилж авсан хүүхдэд 40-80 сая төгрөгний нөхөх олговор олгох ажлын хүрээнд нөхөх олговор нэхэмжлэгч нийт 976 хүнд 59 тэрбум 020 сая төгрөгийн нөхөх олговрыг харьяалах нэгжийн ИТХ-ын дансанд шилжүүлсэн байна.

2020 оны жилийн эцсийн байдлаар нийт давхардсан тоогоор **19,312** иргэнд 75 тэрбум 585,5 сая төгрөгийн нөхөх олговор олгосон байна.

- Хэлмэгдэгчдийн дурсгалыг мөнхжүүлэх. Улсын хэмжээнд нийт хэлмэгдэгчдийн дурсгалыг мөнхжүүлэх чиглэлээр бий болгосон **229** объект байна. Үүнд, нэрэмжит байгууллага, өргөн чөлөө, талбай - 31, хөшөө - 79, суварга - 47, самбар - 29, дурсгалын багана - 27, музейн булан - 16 тус тус хамаарна.

Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисс, “Завхан судлал” төвтэй хамтран Завхан аймгаас улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэж, улмаар цагаатгагдсан хүмүүсийн баримтыг толилуулж байгаа билээ. Энд нийт 2,633 хүний баримт багтсан болно. Эл бүтээлээс өөрсдийн өвөг дээдсийн талаарх үнэн бодит мэдээллийг авч, судалгаа шинжилгээний болон танин мэдэхүйн мэдлэгийг олж чадах аваас хэвлүүлэгч бидний чин хүсэл биелэх болно.

Энэхүү бүтээлийг цувралдаа багтаан хэвлүүлж буй “Завхан судлал төв”-ийн тэргүүн Б.Түвшин, нягтлан зөвлөсөн, түүхийн ухааны доктор (Ph.D), профессор Д.Баярсайхан, Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссийн нарийн бичгийн дарга Д.Ууганбаатар, хариуцлагатай редактор Г.Бямбарагчаа нартаа талархал илэрхийлэе.

Нямжавын **МЭНДБАЯР**
/Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах
улсын комиссын ажлын албаны ахлах референт/

А

Авир Ядамжавын — 1937.12.17-ОБЭК-ын 7
Завхан Цагаанхайрхан — 1990.07.26-ДШЦК-ийн 117
Мээрэн — Цаазлагдсан

Засаг төрийн эсрэг цуурхал тараасан гэж ШЦБ-ийн 43. 47-р зүйлд зааснаар буудан алах, хөрөнгийг нь хураах ялаар шийтгэжээ.

Агваандэндэв Магсарын /1887-1938/ — 1938.05.13-ОБЭК-ын 18
Завхан Цагаанхайрхан Нас 51 — 1992.08.26-ДШЦК-ийн 154
Гүрэмч — Цаазлагдсан

Ёнзонхамба нарын хувьсгалын эсэргүү бүлгэмд элссэн, цуурхал тараасан, гишүүн элсүүлсэн гэж Шүүх Цаазны Бичгийн 43, 44, 47 дугаар зүйлд зааснаар буудан алж, хөрөнгийг хураах ялаар шийтгэжээ.

Адъяа Ёндонгийн /1890-1938/ — 1938.02.11-ОБЭК-ын 4
Завхан Алдархаан Нас 48 — 1991.12.18-ДШЦК-ийн 186
Гавж — Цаазлагдсан

Хувьсгалын эсэргүү бүлгэмд элссэн, бусдыг элсүүлж, цуурхсан гэж Шүүх Цаазны Бичгийн 43, 47 дүгээр зүйлд зааснаар буудан алах ялаар шийтгүүлжээ.

Аюурбунь Хүүхэний /1888-1938/ — 1938.09.19-ОБЭК-ын 32
Завхан Сантмаргац Нас 50 — 1992.11.23-ДШЦК-ийн 192
Лам — Цаазлагдсан

Ёнзонхамбын эсэргүү байгууллагын Завхан аймаг дахь салбарт гишүүнээр элсэн орж, гишүүн элсүүлж, цуурхал тараасан гэж ШЦБ-ийн 43, 44, 47-р зүйлд зааснаар буудан алах, хөрөнгийг нь хураах ялаар шийтгэжээ.

Аюурзана Насантогтохын /1891-1938/ — 1938.05.20-ОБЭК-ын 19
Завхан Цагаанхайрхан Нас 47 — 1993.03.15-ДШЦК-ийн 64
Дооромбо — Цаазлагдсан

Ёнзонхамба нарын эсэргүү бүлэгт элссэн, цуурхал тараасан, эсэргүү ажилдаа хэрэглэх зэвсэг олохыг оролдсон гэж Шүүх Цаазны Бичгийн 43, 44, 47 дугаар зүйлд зааснаар буудан алж, хөрөнгийг хураах ялаар шийтгэжээ.

Аюурсэд Буянтын /1885-1938/ — 1938.10.24-ОБЭК-ын 35
Завхан Ургамал Нас 53 — 1991.10.29-ДШЦК-ийн 165
Лам — Цаазлагдсан

Ёнзонхамбын эсэргүү бүлэгт элссэн, гишүүн элсүүлж, цуурхсан гэж Шүүх Цаазны Бичгийн 43, 44, 47 дугаар зүйлд зааснаар буудан алах ялаар шийтгэгджээ.

Аюуш Бандайн /1878- / 1932.06.22-Завхан аймгийн АШТГ-ын 1
Завхан Идэрцэцэрлэг Нас 54 2012.11.28-МУЕПГ-ын 5/178
Ард, хар Суллагдсан. Эсэргүү бослогод оролцсон, Ардын засгийг устгаж, хуучин эзэрхэг төрийг байгуулахаар зэвсэглэсэн, ард олны санаа сэтгэлийг үймүүлэн тэрсэлж, ихээхэн хохирол учруулсан гэж баривчлагджээ.

Аюуш Тангадын 1930.09.15-29-БНМАУ-ын Ерөнхий
Завхан Цэцэрлэг Нас 61 Шүүн Таслан Газрын өргөтгөсөн хурал
Гадаад яаманд түшмэл, 2 жил тэнсэн 1990.05.18-ДШБХ-ын 04
Бичээч, Занги, Бичгийн гавъяаагаар гүн зэрэгтэй. Хувьсгалт засаг төрд тэрсэлсэн эсэргүү бүлгэмийг байгуулсан, хятадын гол засгийн газар ба японы тагнуулчин Банчин нарт нэр хамтран өргөх бичгийг үйлдсэн, гишүүн элсүүлсэн хятадын мэдэлд колони болгон оруулахыг зорьсон, СССР улсыг зүйл бүрээр гүтгэн муушаасан, феодалын хөрөнгийг хураасан, эрхийг хассан, шашин төрийг тусгаарласан явдлыг эсэргүүцэн тэмцсэн хэрэгт Шүүх Цаазны Бичгийн 12 дугаар зүйлийг баримтлан 2 жилийн тэнсэн ялаар шийтгэжээ.

Аюуш Юнрэндамбын 1937.12.10-ОБЭК-ын 6
Завхан Шилүүстэй 1989.06.05-ДШЦК-ийн 50
Цэрэг Цаазлагдсан
Ю.Аюуш нь цэргийн алба хааж байхдаа 1935 онд японы тагнуулын байгууллагад элссэн гэж 6 жил хорих ял шийтгүүлж ялаа эдэлж байхдаа 1937 онд эсэргүү байгууллагын гишүүнээр Ц.Өвгөнхүүд элсэгдсэн, Японтой Жамъянтив ламаар дамжуулан харьцаж, Өвгөнхүү, Г.Дамба нарын даалгавраар засан сайжруулах газрын барааны агуулах, гараж, хорихуудыг шатаахыг завдаж байсан гэж Шүүх Цаазны Бичгийн 43, 44, 45, 47 дугаар зүйлд зааснаар буудан алж, хөрөнгийг хураах ялаар шийтгэжээ.

Арслан Шагдарын /1867-1938/ 1938.05.27-ОБЭК-ын 20
Хөвсгөл Баянхайрхан Нас 71 1990.08.04-ДШЦК-ийн 126
Тэсийн хүрээний аграмба Цаазлагдсан
Хувьсгалын эсэргүү байгууллагад 1934 онд Сэнгэд элссэн, нууц хуралд суусан, Балданцогт нарын 2 хүнийг элсүүлсэн, цуурхсан гэж Шүүх Цаазны Бичгийн 43, 47 дугаар зүйлд зааснаар буудан алах ялаар шийтгэжээ.

Авир Сандагрэнцэнгийн /1880-1938/ 1938.07.01-ОБЭК-ын 25
Завхан Сонгино Нас 58 1992.11.23-ДШЦК-ийн 194
Гавж Цаазлагдсан
Ёнзонхамба нарын хувьсгалын эсэргүү бүлэгт гишүүнээр элссэн, цуурхал тараасан, зэвсэгт бослогод бэлтгэсэн гэж Шүүх Цаазны Бичгийн 43, 44, 45, 47 дугаар зүйлд зааснаар буудан алж, хөрөнгийг хураах ялаар шийтгэжээ.

Авархүү Чойжилжавын /1891- / 1932 онд баривчлагдсан.
Завхан Завханмандал Нас 41 2002.02.03.15-МУЕПГ-ын 5/16
Тайж Ял тодорхойгүй
Нам, засгаас явуулж байгаа бодлогыг эсэргүүцсэн гэж баривчилжээ.

Авид Балганы /1896-1938/ 1938.10.07-ОБЭК-ын 34
Завхан Тэлмэн Нас 42 1993.09.03-ДШЭК-ийн 88
Лам Цаазлагдсан
Ёнзон хамба нарын хэрэгт холбогдуулан Шүүх Цаазны Бичгийн 43, 44, 45, 47 дугаар зүйлд зааснаар буудан алж, хөрөнгийг хураах ялаар шийтгэжээ.

Авирмэд Бадамын /1897-1938/ 1938.05.06-ОБЭК-ын 17
Завхан Отгон Нас 41 1992.09.08-ДШЦК-ийн 161
Лам Цаазлагдсан
Ёнзон хамба нарын хувьсгалын эсэргүү бүлэгт гишүүнээр элссэн, цуурхал тараасан, гишүүн элсүүлсэн гэж Шүүх Цаазны Бичгийн 43, 44, 47 дугаар зүйлд зааснаар буудан алж, хөрөнгийг хураах ялаар шийтгэжээ.

Лхагва Маамын /1902- / 1939.09.13-БНАМУ-ын ДШТГ-ын 68
Завхан Идэр Нас 37 1957.07.18-ЦАЭК-ын 3
Улсын Худалдааны Гаражийн дарга 7 жил хорих
Хувьсгалын эсэргүү гэж Шүүх Цаазны Бичгийн 43, 45 дугаар зүйлд зааснаар 7 жил хорих ялаар шийтгүүлжээ.

Агваандорж Жалцавын /1896-1938/ 1938.06.03-ОБЭК-ын 21
Завхан Шилүүстэй Нас 42 1992.05.11-ДШЦК-ийн 72
Дооромбо Цаазлагдсан Өөрийн амьдарч байсан хүрээ хийдэд хувьсгалын эсэргүү бүлэгт элссэн, бусдыг элсүүлсэн, удирдагч нартаа тагнуулын мэдээ өгсөн, цуурхсан гэж Шүүх Цаазны Бичгийн 43, 44, 47 дугаар зүйлд зааснаар буудан алж, хөрөнгийг хураах ялаар шийтгэжээ.

Агвааншарав Лувсангийн /1898-1938/ 1938.05.20-ОБЭК-ын 19
Завхан Шилүүстэй Нас 40 1993.03.15-ДШЦК-ийн 64
Гэвхүй Цаазлагдсан
Ёнзонхамба нарын эсэргүү бүлэгт элссэн, цуурхал тараасан, эсэргүү ажилдаа хэрэглэх зэвсэг олохыг оролдсон гэж Шүүх Цаазны Бичгийн 43, 44, 47 дугаар зүйлд зааснаар буудан алж, хөрөнгийг хураах ялаар шийтгэжээ.

Адарсүрэн Самбуугийн /1877-1957/ 1937.11.26-ОБЭК-ын 4
Завхан Алдархаан Нас 60 1991.09.24-ДШЦК-ийн 147
Аграмба Цаазлагдсан
Ёнзонхамбаар толгойлуулсан “Төв” хэмээх эсэргүү байгууллагын орон нутаг дахь салбарт элссэн, бусдыг элсүүлсэн, цуурхал тараасан гэж Шүүх Цаазны Бичгийн 43, 47 дугаар зүйлд зааснаар буудан алах ялаар шийтгүүлжээ.

Адъяа Балжиннямын /1895- / 1938.05.06-ОБЭК-ын 17
Завхан Чандмана-Өлзийт Нас 43 1992.09.08-ДШЦК-ийн 161
Маарамба 10 жил хорих
Ёнзон хамба нарын хувьсгалын эсэргүү бүлэгт гишүүнээр элссэн, цуурхал тараасан, гишүүн элсүүлсэн гэж Шүүх Цаазны Бичгийн 43, 44, 47 дугаар зүйлд зааснаар 10 жил хорьж, хөрөнгийг хураах ялаар шийтгэжээ.

Алгаа Авирмэдийн /1919-1939/ 1939.01.16-ОБЭК-ын 1
Завхан Ургамал Нас 20 1993.03.25-ДШЦК-ийн 67
10-р дивизийн их бууны удирдах салаанд цэрэг Цаазлагдсан

1937 онд цэрэгт татагдан 10-р дивизийн их бууны удирдах салаанд цэргийн алба хааж байсан. Гэндэн, Дэмид нарын эсэргүү бүлэг хэрэгт оролцсон, бусдыг элсүүлсэн, хувьсгалт засгийг устган, хаант засгийг байгуулж, эх орноо японд шилжүүлэхээр бэлтгэсэн, байлдааны зэвсгийг эвдэж, хулгайлах зэргээр хорлон сүйтгэж байсан гэж Шүүх Цаазны Бичгийн 43, 44, 45, 47 дугаар зүйлд зааснаар буудан алах ялаар шийтгэжээ.

Алтангэрэл Аюурын /1868-1938/ 1938.07.01-ОБЭК-ын 25
Завхан Түдэвтэй Нас 70 1992.11.23-ДШЦК-ийн 194
Лам Цаазлагдсан

Ёнзон хамба нарын хувьсгалын эсэргүү бүлэгт гишүүнээр элссэн, цуурхал тараасан, зэвсэгт бослогод бэлтгэсэн гэж Шүүх Цаазны Бичгийн 43, 44, 45, 47 дугаар зүйлд зааснаар буудан алж, хөрөнгийг хураах ялаар шийтгэжээ.

Алтангэрэл Шижээгийн /1884-1957/ 1937.11.26-ОБЭК-ын 4
Завхан Улаагчин Нас 53 1991.09.24-ДШЦК-ийн 147
Гандан хүрээний гавж Цаазлагдсан

Ёнзон хамбаар толгойлуулсан “Төв” хэмээх эсэргүү байгууллагын орон нутаг дахь салбарт элссэн, бусдыг элсүүлсэн, цуурхал тараасан гэж Шүүх Цаазны Бичгийн 43, 47 дугаар зүйлд зааснаар буудан алах ялаар шийтгүүлжээ.

Амгалан Зундуйгийн /1867- / 1931.12.26-Завхан аймгийн шүүхийн 89
Завхан Баян-Уул Нас 64 1999.11.09-МУДШ-ийн 358
Тайж 10 жил хорих

Нам, засаг ард бидэнд их албан татвар, өртөө сумангийн хүнд ачаа оногдуулж, хөрөнгө хогшлыг цөлмөн, лам хуврагуудыг баривчлан, сүм хийдийг устгаж, цэвүүн цаг ирлээ, малын үс ноосыг хамаагүй ихээр хайчлан авч байгаа нь мал барагдахын шинж, ард бид нар эдэлж хэрэглэх идэх уух юмгүй байгаа нь улаан оросын бараа, таваар хил нэвтэрч ирж чадахгүй болсонтой холбоотой, энэ нам, засаг биднээс авахаа мэдээд гурил будаа, цай даалимбаар тасалдаг, бид их зовж тарчилж байна, өвчин эмгэг ихдэж, хүүхдүүд их өвчилж байна, иймд эмч, докторын эм хэрэггүй, зөвхөн олон хүүхэд гаргасан эм хүний шээс их сайн, одоогийн ардын засгаас салж, хуучин засаг тогтож, жаргах цагийг үзэх юмсан хэмээн цуурхал яриа гаргасан гэж Шүүх Цаазны Бичгийн 48 дугаар зүйлд зааснаар 10 жил хорьж, хувьд ногдох хөрөнгийг хураах ялаар шийтгэжээ.

Ананд Эрдэнийн /1885-1938/ 1938.03.04-ОБЭК-ын 8
Завхан Сонгино Нас 53 1992.02.27-ДШЦК-ийн 24
Аграмба Цаазлагдсан

Ёнзон хамбын “Төв” хэмээх хувьсгалын эсэргүү байгууллагад гишүүнээр элссэн, бусдыг элсүүлсэн, эсэргүү даалгавар өгсөн, цуурхсан гэж Шүүх Цаазны Бичгийн 43, 44, 47, 48 дугаар зүйлд зааснаар буудан алж, хөрөнгийг хураах ялаар шийтгэжээ.

Арандал Дамбын /1858-1938/ 1938.05.06-ОБЭК-ын 17
Завхан Сантмаргац Нас 80 1992.09.08-ДШЦК-ийн 161
Ловон Цаазлагдсан

Ёнзон хамба нарын хувьсгалын эсэргүү бүлэгт гишүүнээр элссэн, цуурхал тараасан, гишүүн элсүүлсэн гэж Шүүх Цаазны Бичгийн 43, 44, 47 дугаар зүйлд зааснаар буудан алж, хөрөнгийг хураах ялаар шийтгэжээ.

Аранжин Рэнчиндаваагийн /1875-1938/ 1938.02.11-ОБЭК-ын 4
Завхан Сант-Маргац Нас 63 1991.12.18-ДШЦК-ийн 186
Аграмба Цаазлагдсан

Хувьсгалын эсэргүү бүлгэмд элссэн, бусдыг элсүүлж, цуурхсан гэж Шүүх Цаазны Бичгийн 43, 47 дугаар зүйлд зааснаар буудан алах ялаар шийтгүүлжээ.

Артаа Чойсүрэнгийн /1886-1938/ 1938.05.20-ОБЭК-ын 19
Завхан Түдэвтэй Нас 52 1993.03.15-ДШЦК-ийн 64
Тайж Цаазлагдсан

Ёнзонхамба нарын эсэргүү бүлэгт элссэн, цуурхал тараасан, эсэргүү ажилдаа хэрэглэх зэвсэг олохыг оролдсон гэж Шүүх Цаазны Бичгийн 43, 44, 47 дугаар зүйлд зааснаар буудан алж, хөрөнгийг хураах ялаар шийтгэжээ.

Ашмаа Доржсүрэнгийн /1888-1938/ 1938.05.06-ОБЭК-ын 17
Завхан Чандмана-Өлзийт Нас 50 1992.09.08-ДШЦК-ийн 161
Гавж Цаазлагдсан

Ёнзонхамба нарын хувьсгалын эсэргүү бүлэгт гишүүнээр элссэн, цуурхал тараасан, гишүүн элсүүлсэн гэж Шүүх Цаазны Бичгийн 43, 44, 47 дугаар зүйлд зааснаар буудан алж, хөрөнгийг хураах ялаар шийтгэжээ.

Аюур Хандын /1913- / 1938.01.16-ОБЭК-ын 2
Завхан Жавхлант Нас 26 1957.12.17-ЦАЭК-ын 19

5-р Дивизийн Намын Комиссын дарга. 10 жил хорих. Хувьсгалын эсэргүү гэж 1938 оны 12 дугаар сард баривчлагдан буудан алах ялаар шийтгүүлсэн боловч БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1939 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 80 дугаар тогтоолоор 10 жил хорих ял болгон өөрчилжээ.

Аюурбуян Маань (Мань)-ийн /1883-1938/ 1938.02.18-ОБЭК-ын 5
Завхан Идэр Нас 55 1992.08.10-ДШЦК-ийн 129
Гавж Цаазлагдсан

Ёнзонхамба нарын эсэргүү байгууллагад элссэн, цуурхал тараасан гэж Шүүх Цаазны Бичгийн 43, 44, 47 дугаар зүйлд зааснаар буудан алж, хөрөнгийг хураах ялаар шийтгэжээ.

Аюуш Дунхуугийн /1864-1938/ 1938.04.28-ОБЭК-ын 16
Завхан Цагаанхайрхан Нас 74 1992.07.27-ДШЦК-ийн 113
Дуутын хүрээнд шавилан сууж байсан. Цаазлагдсан

“Төв” хэмээх эсэргүү байгууллагад гишүүнээр элссэн, ардын засгийг устгах зорилгоор цуурхал тараасан гэж Шүүх Цаазны Бичгийн 43, 44, 47 дугаар зүйлд зааснаар буудан алж, хөрөнгийг хураах ялаар шийтгэжээ.

Аюуш Янтайн 1938.02.18-ОБЭК-ын 5
Завхан Улаагчин Нас 47 1991.09.19-ДШЦК-ийн 134
Лам Цаазлагдсан

Ёнзон хамба нарын “Төв” хэмээх бүлгийн орон нутаг дахь байгууллагад элссэн, бусдыг элсүүлсэн, цуурхсан, ардын засгийн эсрэг үйл ажиллагаа явуулж байсан гэж Шүүх Цаазны Бичгийн 43, 44, 47, 48 дугаар зүйлд зааснаар буудан алж, хөрөнгийг хураах ялаар шийтгэжээ.

Аюушжав Мөнхийн /1870-1938/ 1938.02.18-ОБЭК-ын 5
Завхан Нөмрөг Нас 68 1992.08.10-ДШЦК-ийн 129
Гавж Цаазлагдсан Ёнзон хамба нарын эсэргүү байгууллагад элссэн, цуурхал тараасан гэж Шүүх Цаазны Бичгийн 43, 44, 47 дугаар зүйлд зааснаар буудан алж, хөрөнгийг хураах ялаар шийтгэжээ.

Артсэд Эрэндамбын /1889-1938/ 1938.05.06-ОБЭК-ын 17
Архангай Наран Нас 49 1992.10.08-ДШЦК-ийн 164
Аграмба Цаазлагдсан
Ёнзон хамба нарын хувьсгалын эсэргүү байгууллагад элссэн, бусдыг элсүүлсэн, цуурхал тараасан гэж Шүүх Цаазны Бичгийн 43, 47, 48 дугаар зүйлд зааснаар буудан алж, хөрөнгийг хураах ялаар шийтгэжээ.

Б

Баатар Дуламжавын /1875-/ 1932.06.22-Завхан аймгийн АШТГ-ын 1
Завхан Улаагчин Нас 57 2012.11.28-МУЕПГ-ын 5/178
Аравны дарга байсан. Суллагдсан
Эсэргүү бослогод оролцсон, Ардын засгийг устгаж, хуучин эзэрхэг төрийг байгуулахаар зэвсэглэсэн, ард олны санаа сэтгэлийг үймүүлэн тэрсэлж, ихээхэн хохирол учруулсан гэж баривчлагджээ.

Баатар Жамбалын /1888- / 1938.05.06-ОБЭК-ын 17
Завхан Чандмань-Өлзийт Нас 50 1992.09.08-ДШЦК-ийн 161
Гүрэмч 10 жил хорих
